

**ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

2011.03.22

(2010 оны үйл ажиллагааны үр дүн)

№	Үзүүлэлт	Үр дүнгийн үнэлгээ		
		хувь	оноо	
1	Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	1.Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт	91.75%	4.59
		2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	69.81%	4.97
			99.73%	
	3.Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт	90.0%	4.50	
<b>Үнэлгээний дундаж оноо</b>			<b>4.69</b>	
2	Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ	1.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт	94.71%	4.74
		2.Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт	85.72%	4.29
		3.Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт	98.89%	4.94
		4.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	68.20%	4.87
97.43%				
<b>Үнэлгээний дундаж оноо</b>			<b>4.71</b>	
3	Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ	1.Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	96.88%	4.84
		2.Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	99.79%	4.99
<b>Үнэлгээний дундаж оноо</b>			<b>4.92</b>	
4	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	1. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	100.0%	5.00
		2. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	96.67%	4.83
		3. Төсөв, санхүүгийн ил тод байдал	98.57%	4.93
		4. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал	99.0%	4.95
<b>Үнэлгээний дундаж оноо</b>			<b>4.93</b>	
5	Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	1.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ		4.80
		2.Хэрэглэгчийн үнэлгээ	88.0	4.4
<b>Үнэлгээний дундаж оноо</b>			<b>4.60</b>	
<b>Ерөнхий үнэлгээ</b>			<b>95.40%</b>	<b>4.77</b>

# ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

## I. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ҮР ДҮН

Монгол улсын Засгийн газрын 2008-2012 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 94 зорилтын 167 хэрэгжүүлэх арга хэмжээг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2009-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт холбогдох заалтуудыг бүрэн тусгаж хэрэгжилтийг зохион байгуулж ажилласан. Үүний дүнд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 69.81%, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 68.20%-тай хэрэгжиж байна.

Монгол улсын Засгийн газраас 2010 оныг “Бизнесийн орчны шинэтгэлийн жил” болгон зарласан билээ. Төв аймаг 2010 оныг “Үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих жил” болгон зарлаж, үйлдвэрлэл үйлчилгээг дэмжин ажилласнаар 3928 зээлдэгчид 7.5 тэрбум, Жижиг дунд үйлдвэрлэл, Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих сангаас нийт 739 төсөлд 1.3 тэрбум төгрөгийн зээл олгосноор 77 үйлдвэр цех шинээр байгуулагдан үйлдвэр цехийн тоо 248 болж, ЖДҮ-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ 1.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 15.3%-иар, аж үйлдвэрийн салбарын борлуулалтын хэмжээ 4.5 хувиар тус тус өслөө.

“Атрын III аян”-ыг үргэлжлүүлэн тариаланчдыг хөнгөлттэй зээлээр дэмжих, үрийн шинэчлэл, чанарт анхаарч, хур чийгийн хэмжээг нэмэгдүүлж зорилгоор үүлэнд гнөлөөлж зориудаар хүр тунадас оруулах зэрэг олон талт арга хэмжээг зохион байгуулж ажилласны дүнд 2010 онд үр тариа 82651 тн, төмс 50780 тн, хүнсний ногоо 11973 тн-ыг хураан авсан нь 2009 оноос үр тариа 22.4%, төмс 26.4%, хүнсний ногоо 8.9 хувиар тус тус өсч, үр тарианы нэгжээс хураан авсан ургац, төмсний хураан авсан нийт ургацын хэмжээгээр улсдаа тэргүүлсэн.

Харин байгаль цаг уурын давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалан 2010 оны эцэст аймгийн дүнгээр 2710.7 мянган толгой мал тоологдож малын тоо толгой 2009 оноос 21.7% буюу 753.5 мянган толгойгоор буурсны улмаас аймгийн ДНБ-ий үйлдвэрлэл ХБГ-ээр 150.1 тэрбум төгрөг болж өмнөх оноос 1.25 хувиар буурахаар тооцогдож байна.

Улс орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2010 онд 10.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил хийв.

Төсвийн орлого бүрдүүлэхэд урамшуулал, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгож ажилласнаар 2010 онд улсын төсвийн орлогод 1895.0 сая төгрөг оруулж 101.8%, аймгийн төсвийн орлогод 5232.6 сая төгрөг оруулж 103.6 хувь, орон нутгийн төсвийн орлогод 1778.8 сая төгрөг оруулж 93.9 хувь биелүүлж, 3 шатны дүнгээр 8100.8 сая төгрөг оруулж төлөвлөгөөг 101.1 хувиар биелүүлсэн.

Зуунмод сумын үйлдвэрлэл технологийн паркийн техник, эдийн засгийн үндэслэл, мастер төлөвлөгөөг батлуулж, Үйлдвэрлэл технологийн парк байгуулах бэлтгэл ажлууд хийгдэж байна. Энэ ажлын хүрээнд Сэргэлэн сумын нутаг Цагаан хярд хүнд үйлдвэрийн парк байгуулах ажлын эхлэл тавигдаж, БНХАУ-ын 500.0 сая юаны хөрөнгө оруулалттай, жилд 1 сая тн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай Улаанцементийн үйлдвэрийн барилгын суурийн ажлын гүйцэтгэл 30%-тай хийгдэж, Зуунмод суманд Европын технологитой Чех улсын 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалттай “Мах боловсруулах үйлдвэр” баригдаж эхлээд байна.

Ажилгүйдлийг бууруулахад чиглэсэн олон талт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг өрхийн хэрэгцээтэй уялдуулан 2012 онд 6000-н ажлын байр бий

болгохоос 3865 ажлын байр бий болгож, 2012 он хүртэл 1164 ядуу өрхийн амьжиргааг дээшлүүлэхээс 711 өрх буюу сонгогдсон өрхийн 61.0%-ийн амьжиргаа нь дээшилсэн.

Төрийн үйлчилгээг “Нэг цонх”-оос чирэгдэлгүй хүргэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, 25 суманд нэвтрүүлэн, 24 суманд Олон нийтийн интернэт мэдээллийн төв байгуулж төрийн бүх шатны байгууллагын шийдвэр, мэдээ мэдээлэл иргэдэд шуурхай хүрч байна.

Цагдаагийн кобаныг 13 суманд, Замын цагдаагийн байрыг 2 суманд, Зуунмод хотод хөдөлгөөнт эргүүл байгуулж, нийгмийн хэв журам хамгаалах, цагдаагийн алба хаагчдыг ажиллах нөхцлийг сайжруулсны дүнд гэмт хэргийн илрүүлэлт өмнөх оноос 3.2% өсч, малын хулгай 1.1%, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 11.8% буурсан.

## **II. 2010 ОНЫ АЙМГИЙН БОДЛОГЫН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

Бодлого, шийдвэрийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор 2009 оны 2-р сард ХШҮТасаг 27 сумын ИТХ-ын хуралдааны материалд хяналт шинжилгээ хийж, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Үндсэн чиглэлд тусгагдсан зорилтуудыг бүрэн тусгах талаар аймгийн ИТХТ-ийн 2009 оны 24 тоот тогтоол, аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга, аймгийн ЗДТГ-ын даргын хамтарсан 2009 оны 49, 02/286 албан тоотоор үүрэг өгч ажиллав. Энэ ажилд хайнга хандсан сумдын Засаг дарга нарт аймгийн Засаг даргын 2009 оны 471 тоот захирамжаар хариуцлага тооцож ажилласны дүнд бүрэн тусгасан. Үүний үр дүнд томоохон бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг бүх шатандаа жигд зохион байгуулснаар хэрэгжилт бүрэн хангагдах боломжтой болсон.

**Монгол улсын зорилгод суурилсан мянганы хөгжлийн цогц бодлогоос** аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 2010 оны үндсэн чиглэлд Төрийн захиргаа хууль хяналтын салбарын хүрээнд 5, Эрүүл мэндийн салбарын хүрээнд 4, Нийгмийн хамгааллын хүрээнд 2, Үйлдвэрлэл дэд бүтцийн салбарын хүрээнд 17, Байгаль орчны хүрээнд 9, Хөдөө аж ахуйн хүрээнд 6, Санхүүгийн хүрээнд 3, нийт 46 зорилт тусган хэрэгжүүлж ажиллаа.

Аймгийн хэмжээнд хяналтанд авч хэрэгжүүлж байгаа 6 тэргүүлэх чиглэл 77 стратегийн зорилт 200 арга хэмжээ 91,75%-тай хэрэгжиж байна.

**Монгол улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2010 оны Үндсэн чиглэлийн 35** зорилт, 51 арга хэмжээг хяналтанд авч хэрэгжүүлж байна. Эдгээр арга хэмжээнээс аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2010 оны Үндсэн чиглэлд 46 арга хэмжээг тусган 94.71%-тай хэрэгжүүлж ажилласан.

### **Нэг. Эдийн засгийн хүрээнд:**

Эдийн засгийн хөгжлийн гол салбар болох хөдөө аж ахуйн салбар дахь газар тариалангийн үйлдвэрлэлтийн хэмжээ 2009 оны аймгийн нийт ДНБ-ний 2.4%-аар буюу 5 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдсэн хэдий ч байгаль цаг уурын хүндэрлээс шалтгаалан малын тоо толгой 21.8%-аар буурч 766,6 мянган толгой мал хорогдсоноос мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл буурч, аймгийн ДНБ урд оноос 2010 оны ХБГ-ээр 1.25%-аар буурахаар тооцогдож байна.

ДНБ-д эзлэх аж үйлдвэрлэлийн салбараас уул уурхайн үйлдвэрлэлтийн хэмжээ өмнөх оноос буурсан хэдий ч боловсруулах аж үйлдвэрлэлийн хэмжээ 4.6-аар өссөн.

2010 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн төсвийн орлогод 1895.0 сая төгрөг оруулж 101.8%, аймгийн төсвийн орлогод 5232.6 сая төгрөг оруулж 103.6 хувь, орон нутгийн

төсвийн орлогод 1778.8 сая төгрөг оруулж 93.9 хувь биелүүлж, 3 шатны дүнгээр 8100.8 сая төгрөг оруулж төлөвлөгөөг 101.1 хувиар биелүүлсэн.

2010 онд БНХАУ-ын 500 сая юаны хөрөнгө оруулалттай “Улаанцементийн үйлдвэр”, Чех улсын хөрөнгө оруулалттай “Мах боловсруулах үйлдвэр” 1.2 тэрбум төгрөг, Угтаалцайдам, Архуст, Борнуур сумдад европын технологитой Эрчимжсэн хөдөө аж ахуй, Хүнсний үйлдвэрлэл болон Ногоон эрчим хүчний “Агроцогцолбор” байгуулахаар үйл ажиллагаагаа эхлээд байна. Агроцогцолборын хүрээнд Тэжээлийн үйлдвэр, Сүүний үйлдвэр, Ус савлах үйлдвэр, Шахмал түлшний үйлдвэр, Биогазын үйлдвэр, Биодизелийн үйлдвэрүүд 1.8 тэрбум төгрөг, Цээл сумын нутагт Хүхэрт натрийн үйлдвэр 10.7 тэрбум төгрөг нийт 123.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийж эхлээд байна.

2010 онд 10.7 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтаар хот, сум суурин газруудад нийгмийн салбарын барилга байгууламжийг барьж, засварлах ажил хийж, Бүрэн сумын цэцэрлэг, Баянчандмань сумын сургуулийн барилгын ажлыг эхлүүлж, Зуунмод хотын урлаг спортын цогцолбор, өрхийн эмнэлэг, Батсүмбэр сумын хүн эмнэлэг, Эрдэнэсант сумын цэцэрлэгийн барилгууд шинээр баригдаж, Зуунмод хотын цэвэрлэх байгууламж, Нэгдсэн эмнэлгийн барилга, Баян-Өнжүүл, Цээл сумын сургууль, Баянцагаан сумын сургуулийн гал тогоог засварлалаа.

Хүн амын ая тухтай амьдрах нөхцөл бололцоог хангах үүднээс нийтийн зориулалттай 16, 17, 29, 30, 23 дугаар байруудын дээвэр, сантехникийг засварлаж, Жаргалант сумын халаалтын тогоо, шугам сүлжээг шинэчилж, Бүрэн сумын соёлын төв, номын сан, Зуунмод сумын 2-р багийн төв, өрхийн эмнэлгийн барилгыг цахилгаан халаалтын системтэй болгов.

Орон нутгийн замын санд 204.1 сая төгрөг төвлөрч, төвлөрсөн хөрөнгөөр Зуунмод сумын төвийн зам засвар, Зүүндэлгэр багийн 0.6 км хатуу хучилттай зам шинээр барьсан.

2010 онд Баянцагаан, Дэлгэрхаан сум автомашины засварын цэг байгуулснаар 26 сум автомашины болон дугуй засварын цэгтэй болж, нийт 1180 хүнд үйлчилж, 7829.4 мянган төгрөгийн орлоготой ажиллав.

Ахуйн үйлчилгээний газруудын орлого 772.2 сая төгрөгт хүрч, үйлчлүүлсэн иргэний тоо 156.0 мянгад хүрч өмнөх оноос 33.2 мянган иргэнээр нэмэгдсэн байна.

Аймгийн хэмжээнд ноос угаах, ноолуур самнах үйлдвэр 1, эсгийний цех 33, эсгийн гутлын 9 цех ажиллаж, нийт 450 тн ноос угааж, 11160 ширхэг эсгий, эсгий гутал үйлдвэрлэв.

27 сумдын 672 үйлчилгээний газарт мэргэжлийн бус 382 ажиллагсдаас 71% буюу 233 хүнийг мэргэжил олгох сургалтанд хамруулснаар худалдаа үйлчилгээний газарт ажиллаж байгаа мэргэжилтэй ажиллагсад 85.87 хувь болж 34.68 хувиар өссөн.

14 сумын 105 өрх 30.9 сая төгрөгийн нарны үүсгүүр захиалан авснаар нийт 9689 малчин өрхийн 6700 буюу 69.2 хувь нь нарны үүсгүүрээр хангагдаад байна.

Улсын хэмжээнд телевизийн олон сувагтай болгох арга хэмжээ авснаар Си зурвастай байсныг Ки зурвастай болгож 5-р сараас эхлэн малчид телевизийн 17 сувгийг үзэх болсон.

Зуунмод сумаас бусад 26 сумын өрхийн үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгийн эх үүсвэрийг 23.0 сая төгрөгөөр нэмэгдүүлснээр сум бүр 40.0 сая төгрөгийн эх үүсвэртэй болж, үйлдвэрлэл үйлчилгээг дэмжиж ажиллаа.

2010 онд Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж 49 төсөлд 641.3 сая төгрөгийн зээл олгов. Үүнд: сүү боловсруулах чиглэлээр-3, мах боловсруулах чиглэлээр-3, хүнсний ногоо боловсруулах-7, Ноос ноолуур боловсруулах-3, Гурил гурилан бүтээгдэхүүн-2, Мод модон эдлэл-2, Оёмол бүтээгдэхүүн-2, Барилгын материалын үйлдвэрлэл-2, бусад боловсруулах салбарын үйлдвэрлэл-21 тус тус хамрагдаж, нийт төслийн 83.3 хувийг боловсруулах салбарт олгож, төсөл хэрэгжүүлэгчид үйлдвэрлэл үйлчилгээгээ явуулж эхлээд байна.

Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор төсөвт байгууллага болон иргэдийн хэрэгцээг дотоодын бүтээгдэхүүнээр хангах “Нийгмийн хариуцлагын гэрээ”-г 27 сумын 659 аж

ахуйн нэгж, иргэнтэй байгуулж ажилласнаар мах махан, сүү сүүн бүтээгдэхүүн, төмс хүнсний ногоог 100%, эсгийний 43%-ийг хангаж гурил гурилан бүтээгдэхүүний хэрэгцээний 5.8 хувийг хангаж, хангалт 3.8 хувиар өссөн.

Эрдэнэ суманд “Эрдэнэ хүнс” мах боловсруулах үйлдвэр ашиглалтанд орж, Борнуур Баянчандмань Жаргалант, Сүмбэр, Батсүмбэр сумдад тус бүр 5 тонн сүү цуглуулж, хөргөх хөргөлтийн танкир шинээр суурилагдан 920 тн сүүг цуглуулан анхан шатны боловсруулалт хийж сүү боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлсэн.

Мөн Борнуур суманд “Борнуур фүүдс” ХХК-ний хөрөнгө оруулалтаар өдөрт 2.0 тонн сүү боловсруулах хүчин чадалтай бага оврын үйлдвэр, Мөнгөнморьт, Эрдэнэсант сумдад нийт 80 сая төгрөгийн хувийн хөрөнгө оруулалттай өдөрт 0.5-1 тн сүү боловсруулах хүчин чадалтай сүү боловсруулах цехүүд ашиглалтанд орж 4-5 нэр төрлийн 8.6 тн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ.

Аргалант сумын “Жикс” ХХК, Баянчандмань сумын “Мон таримал” ХХК-ууд “Малын эрүүл мэнд, мал аж ахуйн зах зээл” төслийн 40 хувийн хөрөнгө оруулалтаар өдөрт 5 тн сүү боловсруулах хүчин чадалтай сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах цех шинээр байгуулж, тоног төхөөрөмжөө суурилуулж үйл ажиллагаагаа эхлүүлэхэд бэлэн болов.

2010 онд 1 үйлдвэр, 16 цех ажиллаж 3.2 мянган тонн сүү боловсруулан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 1.8 мянган тн-оор илүү байна.

Аймгийн хэмжээнд 2710.7 мянган толгой, үүнээс тэмээ 2227, адуу 199837, үхэр 171990, хонь 1358744, ямаа 977911 тус тус тоологдож, 623.3 мянган төл бойжсон нь урд оноос бойжсон төл 41.8 хувь, малын тоо толгой 21.8 хувиар буурсан. Гэвч улсын хэмжээнд малын тоо толгойгоор Хөвсгөл аймгийн дараа хоёрдугаарт орж байна.

2010 онд цөм сүргийн малын тоо 135.0 мянга болж урьд оноос 3.8 хувиар, цэвэр эрлийз малын тоо 105.0 мянга урьд оноос 4.0 хувиар тус тус өсөж, сүрэгт эзлэх хувийн жин 8.0 хувь болов.

Мах, сүү болон бусад ашиг шимийн чиглэлийн мал, амьтад үржүүлдэг аж ахуй, фермер энэ онд 270 хүрч урьд оноос 5.1 хувиар, эдгээрт хамрагдах малын тоо 11.0, амьтдын тоо 112.0 мянган толгойд хүрч урьд оноос 2.3-14.3 хувиар тус тус өсөн, 12.0 тн гахайн мах, 11.7 сая ширхэг өндөг, 0.4 тн зөгийн бал, 45 ширхэг туулайн арьс, 60.0 кг туулайн мах үйлдвэрлэж, нэгжийн ашиг шимийн гарц, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлснээр хөдөлмөрийн бүтээмж, малчдын ахуй амьдрал дээшилж байна.

Сум дундын отрын бүс нутгийн хамгаалалт, ашиглалтыг сайжруулах аймгийн бодлого гарган мөрдөж, Малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн нийт ногоон тэжээл 11756.8 тн, үйлдвэрийн тэжээл 1611.9 тн, гар тэжээл 1450.6 тн-ыг бэлтгэв. Мал эмнэлгийн анхан шатны нэгжийн үйл ажиллагааг дэмжин, улсын стандартыг 71 мал эмнэлгийн нэгжээр хангуулж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 20 нэр төрлийн арга хэмжээнд 2023.3 мянган мал, угаалга тарилга туулгалтанд 2027.3 мянган мал хамрууллаа.

Улсын төсвийн хөрөнгөөр 16, бүс нутгийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 25 худаг, нийт 41 шинээр гарган, 2.756.1 мянган га бэлчээр усжуулж, бэлчээр усжуулалтыг 51.0%-д хүргэв.

Газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа 10438 иргэн, 303 аж ахуйн нэгж нийт 50346.3 га-д үр тариа, 3982.8 га-д төмс, 1118.6 га-д хүнсний ногоо тариалж, үр тариа 82650.95 тн, төмс 50780.4 тн, хүнсний ногоо 11973.3 тн хураан авч, буудайн хангамж 385.2%, төмсний хангамж 682.8%, хүнсний ногооны хангамж 144.1%, гурилын хангамж 233.7% -тай байна.

2010 онд 480.56 га талбайн 18 услалтын системийг улсын комисс хүлээн авснаар аймгийн хэмжээнд усалгаатай тариалангийн талбай 2400 га-д хүрч өмнөх оноос 300 га талбайгаар нэмэгдсэн.

### **Хоёр. Нийгмийн хөгжлийн хүрээнд:**

Багш нарын тогтвортой ажиллах, тасралтгүй хөгжих орчинг бүрдүүлж, ажиллах нөхцлийг сайжруулснаар аймгийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын мэргэжлийн багшийн хангалт 88.5%, ЕБС-ийн мэргэжлийн багшийн хангалт 99.1%-тай болж өмнөх оноос өссөн.

2010-2011 оны хичээлийн жилд 6 настай хүүхдийн хамрагдалт 84.9%, суурь боловсролын хамран сургалт 76.9%.

Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын стандартын харьцуулсан үзүүлэлт 98.9%, АВ-ийн эзлэх хувь 58.91 байна.

Ерөнхий боловсролын сургуулийн ширээ сандлын 60 хувийг, зөөлөн эдлэлийн 56.6 хувийг, Дотуур байрны гал тогооны тоног төхөөрөмжийн 76.6 хувийг тус тус шинэчилж, дотуур байрны тасгийн 62.7 хувийг гэрийн нөхцөлд ойртуулж тохижууллаа.

Сургууль завсардсан 315 хүүхдийн 277 буюу 87.9%-ийг Гэгээрэл төвөөр сургалтанд хамруулсан нь өмнөх оноос 0.8 хувиар, бичиг үсгийн зуны сургалтыг 25 сум зохион байгуулж 243 хүн бичиг үсгийн чадвараа ахиулж, бичиг үсэг үл мэдэгч 121 иргэдээс 82 буюу 67.3% нь бичиг үсэгт тайлагдсан нь өмнө оны мөн үеэс 4.4 хувиар тус тус ахисан.

“Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр орон нутгийн аж ахуйн нэгжээс 23 сургууль буюу 76.6% нь шаардагдах бүтээгдэхүүнээ авч хэрэглэн, 15 сургууль цайны газартаа үдийн цайгаар үйлчилж, халуун хоолоор үйлчлэх боломжийг 20 сургууль буюу 66.6% нь хангасан. ЕБ-ын 15 сургууль мал аж ахуй, 15 сургууль газар тариалан эрхэлж мах, аарц, ногоо нөөцлөн Үдийн хоол, дотуур байрны хоол хүнсэнд хэрэглэж байна.

Алтанбулаг сумын сургууль “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэх загвар сургууль болох Тайландын “Гүнжийн сан”-ийн төсөлд хамрагдан туслах аж ахуйгаасаа 103 л сүү, 300 л тараг бэлтгэн үдийн хоолны хэрэгцээнд хэрэглэсэн.

Соёл урлагийн байгууллагуудын мэргэжлийн боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлэх зорилгоор Соёлын дээд сургуульд 5, СУИС-д эчнээ ангид 5 сумын соёлын төвийн эрхлэгчийг, 2009-2010 хичээлийн жилд СУИС-ын драмын ангид 9 оюутан суралцуулан төгсгөснөөр мэргэжлийн боловсон хүчний хангалт Монгол туургатан театр 96 %, Аймгийн нийтийн номын сан 100%, Аймгийн музей 40%, сумдын соёлын төвийн эрхлэгч 90%, Хөгжмийн багш 34.6%, Бүжгийн багш 11.5%, Сум сургуулийн номын санчид 25% болж мэргэжлийн боловсон хүчний хангалт өмнөх оноос 19.3% -иар өссөн.

Аймгийн Музейн сан хөмрөгийн баяжилтыг 4100.0 мянган төгрөгөөр хийж нийт 18 үзмэр худалдаж аваад байна.

БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар “Монгол туургатан театр”-т 9.3 сая төгрөгийн хөгжим, техник хэрэгсэл, орон нутгийн 30.0 сая төгрөгөөр 320 ш сандлыг шинэчилсэн.

Аймгийн хэмжээнд эхийн эндэгдэл гаргаагүй эерэг үзүүлэлттэй боловч нялхсын эндэгдлийн түвшин 25.89 промилль болж, өнгөрсөн оноос 7.65 промилиор, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл амьд төрсөн 1000 хүүхдэд 4.31 промилль болж, 2.16 промилиор, 686 халдварт өвчин бүртгэгдсэн нь 10000 хүн амд 78.67 промилль болж өнгөрсөн оноос тус тус өсч, дархлаажуулалтанд хамрагдалт 98.83%-д хүрч өмнөх оноос буурч хүрсэн түвшингээсээ ухарсан явдалд дүгнэлт хийж цаашид эмч эмнэлгийн мэргэжилтний мэдлэг чадвар, хариуцлагыг дээшлүүлэх, сумдын эмнэлгийг мэргэшсэн, тогтвор суурьшилтай ажиллах боловсон хүчнээр хангах бодлого барьж, хариуцлагын тогтолцоог сайжруулахаар ажиллаж байна.

Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн стандарт хангалтын хувь сумын эмнэлэгт 84.3%, ӨНЭ-т 98.0%, АНЭ-т 98.2%, дунджаар 93.5 хувьд хүрсэн.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогоор 6113.7 сая төгрөг оруулахаас 6693.9 сая төгрөг оруулж төлөвлөгөөг 109.4 хувиар биелүүлэв. Аймгийн хэмжээнд нийт 12668 малчин, оюутан, ажилгүй иргэнийг ЭМД-д хамруулаад байна.

2010 онд Хүний хөгжил сангаас 9.2 млрд төгрөгийг нийт 83652 хүнд олгоод байна.

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих ажил үйлчилгээнд 910 иргэн, Нийгмийн халамжийн ажил, үйлчилгээнд 2147 иргэн, ЗДТГ болон улс, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн ажил үйлчилгээнд 836 иргэн хамрагдан, 2000 гаруй хүнд 979.7 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, 705 хүнд 215.5 сая төгрөгийн нөхцөлт мөнгөн тэтгэмж, жирэмсэн амаржсан нярай хүүхэдтэй 2157 эхэд 489.4 сая төгрөгийн тэтгэмж олгосон.

Ажиллах хүчний оролцооны түвшин 71.3%, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 69.8 хувьтай байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 15.0-30.0 сая төгрөгийг сумдад хуваарилан олгож 605 ажлын байр шинээр бий болгон, жижиг дунд үйлдвэрийн сангаас 641.3 сая төгрөг олгож 213 ажлын байр, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд зориулж 250 өрхөд 350.0 сая төгрөгийн зээл олгон 378 ажлын байр тус тус бий болгов.

2010 онд 1442 иргэнийг ажилд зуучлан, зээл, төсөл хөтөлбөрт хамруулах, иргэд, орон нутгийн санаачилгыг дэмжих замаар 1858 ажлын байр шинээр бий болгон E-job сайгад мэдээллийг нь орууллаа.

### **Гурав. Байгаль орчин, газрын хүрээнд:**

Аймгийн хэмжээнд 2003-2010 он хүртэл 12125 иргэнээс газар өмчилж авах санал ирүүлэснээс 12008 иргэн 3275.13 га газрыг өмчлүүлж 99.0 хувьтай байна. 2010 онд 2004 иргэнээс санал ирүүлэснээс 1919 иргэнд 510.1 га газрыг өмчлүүлж 95.7 %-тай байна.

Ойжуулалт, ойн зурвасанд шаардлагатай тарьц, суулгацыг ургуулах ажлыг Лүн суманд БНСУ-ын хөрөнгө оруулалтаар 12 га талбайд байгуулсан мод үржүүлгийн газарт навчит модны суулгац 3.0 мянган ширхэг, Сэргэлэн сумын мод үржүүлгийн газарт чацарганы 1.2 настай суулгац 1.2 мянга, шинэсний 1.2 настай тарьц 175.0 мянга, Мөнгөнморьт сумын Хорих 417-р анги шинэсний 1 настай тарьц 50.0 мянган ширхэг, нийт тарьц 225.0 мянган ширхэг, суулгац 4.2 мянган ширхэгийг ургуулав.

Байгаль хамгаалахад иргэдийг татан оруулах ажил зохион байгуулснаар 20 суманд 82 нөхөрлөл байгуулагдаж, 260.0 мянган га ой, ан, ургамлын эдэлбэр нутгийг хариуцан хамгаалж байна.

2010 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 5, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 13 суманд 30, тогтвортой амжиргаа 2 төслийн хөрөнгөөр 5, нийт 40 булаг, рашааны эхийг хамгаалж тохижуулан, энэ ажилд 30.8 сая төгрөг зарцуулав.

Бүх нийтээр мод тарих “Монголоо ногооруулья” аяны хүрээнд төв суурин газрыг цэцэрлэгжүүлэх, ногооруулах ажилд 27 сумын 297 байгууллага, аж ахуйн нэгж, 7560 иргэд оролцож, 101462 ширхэг мод, бут, сөөгийг тарьж, 16.1 га талбайг зүлэгжүүлэн, 294.5 сая төгрөг зарцуулсан.

Ойн сан, усны ай савд олгогдсон ашиглалтын 42 тусгай зөвшөөрөл бүхий 7917 га, хайгуулын 46 тусгай зөвшөөрөл бүхий 82563.16 га газар, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл авснаас хойш 2 ба түүнээс дээш жилээр үйл ажиллагаа явуулаагүй 130 тусгай зөвшөөрөл бүхий 402070.13 га газар, орон нутгийн санал аваагүй болон татгалзсан санал өгсөн байхад олгогдсон ашиглалтын 10 тусгай зөвшөөрөл бүхий 2485 га газар, хайгуулын 71 тусгай

зөвшөөрл бүхий 212396.93 га газруудын тусгай зөвшөөрлүүдээс 51 аж ахуйн нэгжийн 67000 га талбай бүхий тусгай зөвшөөрлийг цуцлуулсан.

Аймгийн хэмжээнд уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас “Алт” хөтөлбөр хэрэгжсэнээс хойш 9659.7 га талбай хөндөгдсөнөөс 2010 оны жилийн эцсийн дүнгээр 2728.5 га буюу 28.2 хувьд техник, 1249.3 га буюу 12.93% биологийн нөхөн сэргээлт хийснийг тогтоон, зураглалд оруулсан.

27 сумын хэмжээнд 147 усан сан бүхий газрын **233596.1** мянган га талбайд энгийн хамгаалалтын бүс тогтоож, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий **20617.5** га талбай орсоноос **6563.2** га талбай нь ашиглалтын, **14053.9** га талбай нь хайгуулын тусгай зөвшөөрөлд хамрагдаж, эдгээр талбайд хамаарах лицензүүд цуцлагдсан.

Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх 2 экспедици 12 удаагийн цаг агаарын процесс дээр ажиллан, 2 удаагийнх амжилтгүй, 10 удаагийнх нь амжилттай болж давхардсан тоогоор 17 сумын нутагт 36 удаа тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаа явууллаа.

### **Дөрөв. Төрийн захиргаа, хууль хяналтын хүрээнд:**

Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах ажлын нэг хэсэг болсон төрийн албан хаагчдын чадавхийг бэхжүүлэх, төр засгийн тогтоол шийдвэрийн биелэлтийг орон нутагт зохион байгуулах ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор сумдын ажил дүгнэх журмыг шинэчлэн урамшуулал-хариуцлагын тогтолцоо бүрдүүлэн, аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийг 2 удаа явуулж, сумдын ажлыг хагас бүтэн жилээр дүгнэж хэвшсэн.

27 сумын ажлын явцыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.52 хувиар ахиж аймгийн дүнгээр 91.0 хувьтай дүгнэгдсэн нь ажлын явц үр дүн, үйл ажиллагаа тогтмолжиж байна.

Аймгийн ЗДТГазрын хэлтэс, Засаг даргын дэргэдэх агентлаг, аймгийн харьяа байгууллагын үйл ажиллагааг улирал бүр дүгнэн, үйл ажиллагааны явцын хяналт шинжилгээ үнэлгээг Иргэд, иргэний нийгмийн байгууллагатай хамтран хийх журмыг хэрэгжүүлэн ажилласнаар төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд Иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн хөндлөнгийн үнэлэлт дүгнэлт хийх боломжоор ханган ажиллав.

Орон нутгийн бүх түвшинд үйл ажиллагааны үр дүнд хийх хяналт шинжилгээ, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгож, үнэлгээг хараат бус бодит түвшинд хийхэд дэмжлэг үзүүлэн анх удаа аймгийн ЗДТГ-ын харьяанд Дотоод аудит, Хяналт шинжилгээ үнэлгээний албыг бие даасан байдлаар байгуулан ажиллуулж байна.

Төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээг шат дамжлагагүй болгох, шударга шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилгоор аймгийн төвд “Нэг цэгийн үйлчилгээ”-ний байраар 2010 онд Нийгмийн даатгалын хэлтэс, Газрын алба, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн алба, Нотариат, Иргэний бүртгэл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, ХААН банкны үйлчилгээг 140.0 гаруй мянган иргэдэд үзүүлэв. Мөн 26 суманд нэг цэгийн үйлчилгээ байгуулахаар зорилт тавин ажиллаж сумдын 92,6% нь нэг цэгийн танхимтай болсон.

Төрийн байгууллагуудаас иргэдэд төрийн үйлчилгээг сурталчлах, түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, иргэдийн өргөдөл хүсэлтийг бодитой шийдвэрлэх, санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусган ажиллах зорилгоор аймгийн хэмжээнд улирал бүр “Нээлттэй хаалганы өдөр”-ийг 27 сум, 25 байгууллагыг хамруулан зохион байгуулж ажилласнаар давхардсан тоогоор 37599 орчим иргэнд үйлчилгээ үзүүлж, сурталчилгаа, таниулга хийв.

Гадаад харилцаа хамтын ажиллагааг эдийн засгийн үр өгөөж рүү чиглүүлсэн, иргэдийн аж амьдрал, аймаг орны эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулсан, бодитой үр дүнд хүргэх чиглэл барьж ажилласны дүнд 7 улсын 9 муж хо той шууд хар ицаа хамтын ажиллагааны түвшинд, Зүүн Азийн 11 орны 11 мужтай найрамдалт харилцаатай ажиллаж, 2009-2010 онд харилцаат муж болон хамтран ажилладаг олон улсын байгууллагаас нийт 316 төлөөлөгч хүлээн авч, 223 хүн харилцаат мужуудад явж, эдгээр арга хэмжээнд 163.9 сая төгрөг зарцуулсан ч манай аймгийн ХАА газар тариалан, мал аж ахуй, эрүүл мэнд, нийгмийн салбарт 745.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт орж ирсэн.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд хууль сахиулах болон иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хамтын ажиллагааг уялдуулж, үйл ажиллагааг өргөжүүлж ажилласнаар энэ онд бүртгэгдэх үедээ эзэн холбогдогч нь тогтоогдоогүй 73 хэргээс 47 хэргийг нөхөн илрүүлж хэргийн илрүүлэлт 64.3 хувь болсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 3.2 хувиар өссөн байна.

13 суманд Цагдаагийн кобань байгуулж, Тээврийн хэрэгслийн хяналт шалгалтын иж бүрэн цогцолбор төвүүдийг байгуулах үйл ажиллагааны зардал 120.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, Лүн, Баянчандмань суманд Замын цагдаагийн харуулын байр, Борнуур суманд сумын хөрөнгө оруулалтаар кобань барьж ашиглалтанд оруулан хөдөө орон нутагт ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлээд байна.

Аймгийн хэмжээнд малын хулгайн гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй газар орон нутгийг судалгаагаар тогтоон малчид, малчдын бүлгүүдтэй хамтарсан болон Хөдөлгөөнт эргүүл шалгалтыг хулгайн тээвэр хийж болзошгүй зам, даваа, сэжигтэй объектод ажилласны дүнд малын хулгайн гэмт хэрэг өнгөрсөн оноос 1.1 хувиар буурлаа.

“Архидалтгүй амьдралын хэвшил-нийгмийн эрүүл орчин” аяныг жилийн турш өрнүүлж, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх олон талт ажлыг Иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоонд тулгуурлан зохион байгуулсны дүнд 2010 онд согтуугаар үйдэгдсэн гэмт хэрэг 11.8 хувиар буурлаа.

2010 онд давхардсан тоогоор 741 гадаадын иргэдийн бичиг баримтанд үзлэг шалгалт хийж 15 зөрчил илрүүлэн, 4.3 сая төгрөгийн торгууль ногдуулан төюлөрүүлж, БНХАУ-ын 13, ОХУ-ын 1 иргэнийг тус тус албадан гаргасан.

### **III. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ҮР ДҮН**

2010 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт 85,72%-тай байна. Үүнээс ЗГ-ын тогтоол 84,66%, хуралдааны тэмдэглэл 90,63%-тай хэрэгжсэн. Тайлант хугацаанд шинээр нийт 85 шийдвэрийг хяналтанд авч, Засгийн газрын 77 тогтоолын 150 заалт, Засгийн газрын хуралдааны 20 тэмдэглэлийн 34 заалт, нийт 97 шийдвэрийн 184 заалтыг 5 хэлтэс 20 агентлаг, харьяа 5 байгууллагад хяналтын картаар хариуцуулан өгч ажиллав. Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор 2010 онд аймгийн ИТХ, ИТХТ-ийн 18 тогтоолоор дэд хөтөлбөр, бодлого, төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 9 захирамжаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлан хэрэгжүүллээ. Үүний үр дүнд тасарсан болон зохион байгуулалтаас шалтгаалан удаашралтай хэрэгжиж байгаа заалт байхгүй.

Сумдад хяналтанд авч хэрэгжүүлж байгаа Засгийн газрын болон нутгийн удирдлагын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг электрон шуудангаар авч дүгнэхэд хугацаа хоцроосон сум гараагүй. Сумдын “Олон нийтийн интернет мэдээллийн төв”-ийг ашиглан шийдвэрийн хэрэгжилтэнд ХШҮ хийснээр тайлан ирүүлэлт сайжирч, харилцан мэдээлэл

солилцоход хугацаа хоцроох явдал багасч, бичиг хэргийн зардал буурах зэрэг ач холбогдолтой байна.

Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх зорилгоор 30 байгууллагад явцын хяналт, улирал бүр хяналт шинжилгээ үнэлгээ хийн дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал болон байгууллагын мэдээллийн цагаар мэдээллээ. Мөн хэрэгжилтүүдийг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэрийн хэрэгжилт болон хөтөлбөрийг эрчимжүүлэх талаар аймгийн Засаг даргын захирамжаар өгсөн үүрэг даалгаварын хэрэгжилтийг тооцож ажиллав.

Монгол Улсын Засгийн газраас баталсан Үндэсний хөтөлбөрүүдийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор өөрийн аймгийн онцлогтой уялдуулан, салбар хариуцсан мэргэжилтнүүдийн хийсэн судалгаа, дүгнэлтэнд тулгуурлан бодлого зохицуулалтын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, явцад нь хяналт шинжилгээ хийж үр дүнд хүргэхэд анхаарч ажиллаж байна.

2010 онд 86 үндэсний хөтөлбөр, 56 дэд хөтөлбөрийг хяналтанд авч, жагсаалтыг шинэчлэн холбогдох хэлтэс, агентлаг сумдад хүргүүлж аймгийн веб сайтад тавьсан. 5 төслийг хяналтанд аван хэрэгжилтийг хангуулан ажиллаа.

Үндэсний болон дэд хөтөлбөр, төслийн хэрэгжилтэнд жилийн эцсийн байдлаар хяналт, шинжилгээ, үнэлгээ хийхэд 86 үндэсний хөтөлбөр 90.0%-тай, ИТХ-ын тогтоолоор батлагдсан 11 бодлого хөтөлбөр, төлөвлөгөөний 749 хэрэгжүүлэх арга хэмжээ 69.0%-тай, ИТХТ-ын хурлын тогтоолоор батлагдсан 20 бодлого хөтөлбөр төлөвлөгөөний 652 хэрэгжүүлэх арга хэмжээ 80%-тай, нийт ИТХ, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын тогтоолоор батлагдсан 31 бодлого хөтөлбөр, төлөвлөгөөний 1401 хэрэгжүүлэх арга хэмжээ 79.07%-тай, 5 төсөл 90 %-тай хэрэгжиж байна. Үндэсний болон дэд хөтөлбөр, төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор бодлогын баримт бичгүүдэд тусгаж хэрэгжилтийг хангаж ажиллав.

#### **IV. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС АЙМГИЙН ЗДТГ-ЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРТЭЙ БАЙГУУЛСАН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ:**

2010 онд бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээний биелэлтийг бүтээгдэхүүн тус бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /тоо хэмжээ, чанар, хугацаа, өртөг/-ийн болон хүрэх үр дүнгийн хэрэгжилтийг хагас жил, жилийн эцсийн байдлаар гаргаж аймгийн Засаг даргаар ажлаа дүгнүүллээ.

Жилийн эцсийн байдлаар нийлүүлбэл зохих нийт 14 бүтээгдэхүүнд авбал зохих 30 онооны 29.79, тусгай захиалгат 1 бүтээгдэхүүнд авбал зохих 40 оноо, өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх 3 бүтээгдэхүүнд авбал зохих 30 ою о гавч нийт 99.79 оноо авч, “А” буюу “маш сайн” үнэлгээ авлаа.

Аймгийн ЗДТГ-ын Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээнээс аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2010 оны Үндсэн чиглэлд тусгагдсан зорилтууд, захиргааны удирдлага зохицуулалт, захиргааны стандартын хангалт, гадаад харилцаа хамтын ажиллагаа, мэдээллийн технологи сүлжээний ашиглалт, захиргааны дотоод зохицуулалт, иргэд олон нийттэй харилцах, иргэдийн санал, өргөдөл гомдлыг шийдвэрлэх болон өмчлөлийн зорилтыг хангахад чиглэсэн бүтээгдэхүүнүүд бүрэн хангалттай хэрэгжлээ.

#### **V. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ /САЙД/ НАРААС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

<b>Бүтээгдэхүүний ангийн тоо</b>	<b>Үүнээс тасарсан</b>	<b>Биелэлтийн дундаж хувь</b>	<b>Оноо</b>	<b>Үнэлгээний коэффициент</b>	<b>Үнэлгээний оноо</b>
--------------------------------------	------------------------	---------------------------------------	-------------	-----------------------------------	----------------------------

46	-	96.88	4.84	1.0	4.84
----	---	-------	------	-----	------

Төсвийн ерөнхийлөн захирагч /10 яамны сайд/ нараас аймгийн Засаг даргатай 2010 онд байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээгээр 41 ангийн бүтээгдэхүүн нийлүүлэхээс 41- г нийлүүлж, тасарсан бүтээгдэхүүний анги байхгүй.

Гэрээнээс **БХЯамны хүрээнд:** Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавих, Цэргийн үүрэгтний бүртгэл хөтлөх, сургаж, бэлтгэх, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, цэрэг татлага зохион байгуулах, цэргийн албыг дүйцүүлэн хааж буй иргэдтэй сургалт явуулах, мөнгөн төлбөрийн тооцоо хийх, Дайчилгааны төлөвлөгөөг тодотгож, баталгаажуулах, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах зэрэг 3 бүтээгдэхүүний анги, **НХХЯамны хүрээнд:** Хүн амын хөгжлийг дэмжих үйл ажиллагаа, нийгмийн даатгалын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ, орон нутгийн ахмадын байгууллагыг дэмжих үйлчилгээ зэрэг 3 бүтээгдэхүүний анги, **МУ-ын Шадар сайдын хүрээнд:** бодлогыг хэрэгжүүлэх, хүүхдийн оролцоог дэмжих зэрэг 2 бүтээгдэхүүний анги, Тэргүүн шадар сайдын хүрээнд стандартчилал хэмжилзүйн бодлогыг хэрэгжүүлэх, **БОАЖЯамны хүрээнд:** Ойжуулалт, ойн арга хэмжээ, байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ зэрэг 2 бүтээгдэхүүний анги, **ХЗДХЯамны хүрээнд:** Өмчлөлийн эрхийг хэрэгжүүлэх зэрэг 11 бүтээгдэхүүний анги 100 хувь хэрэгжсэн байна.

## **ҮІ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР АВСАН АРГА ХЭМЖЭЭ, ҮР ДҮН**

Төрийн байгууллагуудаас иргэдэд төрийн үйлчилгээг сурталчлах, түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх, байгууллагуудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах үүднээс байгууллага бүр вэб сайттай болж түүгээрээ дамжуулан үйл ажиллагаагаа иргэдэд тайлагнан, сурталчилж, мэдээ мэдээллээ богино хугацаанд хүргэж байна.

27 суманд Олон нийтийн интернэт мэдээллийн төвийг байгуулж, бүх сумд вэб сайттай болсон. Тус вэб сайтуудад сумын төвийн төсөвт байгууллагууд өөрийн танилцуулга, эрхэм зорилго, зорилт, албан хаагчдын хаяг, холбоо барих утас, байгууллагын дүрэм, хариуцах асуудал зэргийг байршуулж, сумд сар бүр ажлын тайлангаа аймгийн вэб сайтад байрлуулж хэвшсэн.

Агентлаг, байгууллагууд төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт болон төлбөртэй үйлчилгээ үзүүлэх журам, холбогдох эрх зүйн үндэслэлийг байгууллагын мэдээллийн самбар болон “Нэг цонхны үйлчилгээ”-ний танхимд салбар салбараар харгалзах цонхон дээр байршуулж ажиллаж хэвшсэн. Нэг цонхын үйлчилгээг орон нутагт хэвшүүлэх зорилт дэвшүүлж 27 сумын 25 нь буюу 92.5% нь 4-7 хүний бүрэлдэхүүнтэй танхим байгуулан төрийн үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгож үр дүнд хүрч байна.

Төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа иргэдэд сурталчлах, нээлттэй ил тод болгох зорилгоор “Нээлттэй хаалганы өдөр”, өдөрлөгийг 2010 онд 25 байгууллага 27 суманд ажилласнаар давхардсан тоогоор 37599 орчим иргэнд үйлчилгээ үзүүлж, сурталчилгаа, таниулга хийв.

Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх бодлогын баримт бичигт иргэдийн саналыг тусгах зорилгоор 2010 онд “Үйлдвэржүүлэх төлөвлөгөө” боловсруулахад 21 сумын 700 гаруй иргэдийн санал авч, нийт саналын 60 гаруй хувийг тусгаж батлуулсан. “Хүний эрхийг хангах арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг 26 сум, аймгийн төвийн нийт 2310 иргэнээс санал асуулга авч, ИТХурлаас гарах шийдвэрийн төсөлд тусгах, хэрэгжилтийн байдалд дүгнэлт өгөх, судалгаа мэдээлэлд ашиглав. “Өрхийн хөгжлийн дэмжих” хөтөлбөрийг боловсруулахад 4 байгууллага, сумдын ИТХ-ын төлөөлөгч 15, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, ажлын албаны 12

болон 60 гаруй иргэдээс санал авч, төлөвлөгөөнд тусгаж батлууллаа. Аймгийн хэмжээнд жил бүр томоохон бодлогын баримт бичиг боловсруулахад иргэдээс санал авах, хэлэлцүүлэг хийх ажил хэвшсэн.

### **ДҮГНЭЛТ**

Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны 2010 оны үр дүнгийн үнэлгээг Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу урьдчилсан байдлаар тооцож дүгнэхэд үнэлгээний оноо 4.77 байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Ц.ЭНХБАТ